



АРХАНГАЙ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018/12



[www.nso.mn](http://www.nso.mn) [www.arkhangai.nso.mn](http://www.arkhangai.nso.mn) [www.1212.mn](http://www.1212.mn)



## ӨРХ ХҮН АМ

2018 оны эцэст манай аймагт урьдчилсан дүнгээр 27.9 мянган өрх, 95.9 мянган хүн амтай байна. Нийт хүн амын 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж хүйсийн харьцаа 100.4 байна. Өрх хүн амыг байршлаар нь авч үзвэл нийт өрхийн 18.2 хувь нь буюу 5.4 мянган өрхийн 17.5 мянган хүн сумын төвд, 23 хувь буюу 6.1 мянган өрхийн 22.1 мянган хүн аймгийн төвд оршин сууж байна.

Нийт өрхийн дотор 2 ихэр хүүхэдтэй 244 өрх байгаа бол 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 1590 өрх байна. 2096 ганц бие өндөр настан өрх байгаагийн 72.5 хувь нь 55 ба түүнээс дээш насны эмэгтэй байна. Аймгийн дүнгээр өрхийн дундаж ам бүл 3.4, хүн амын нягтрал 1 км<sup>2</sup>-д 1.7 байна.

Аймгийн хэмжээгээр 90-99 настай 91 хүн, 100-аас дээш настай 6 хүн байна.

Өрх толгойлсон 2484 эмэгтэйчүүд байгаагийн 4.7 хувь нь 6 ба түүнээс дээш ам бүлийг тэжээж байна.

Аймгийн хэмжээнд 1502 өнчин хүүхэд байгаагийн 6.7 хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байгаа ба нийт өнчин хүүхдийн 35 хувийг 0-9 насны хүүхдүүд эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 3523 хүн байгаагаас 1451 нь эмэгтэй, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 1632 хүн байна.



## СОЁЛ УРЛАГ, БОЛОВСРОЛ

Хөгжимт драмын театр 2018 онд 12 уран бүтээл шинээр хийж 43 удаа тоглолт зохион байгуулан давхардсан тоогоор 39.0 мянган хүнд үйлчилж урын сандаа 42 бүтээлтэй байна.

Өнгөрсөн оныхоос тоглолт, үзэгчдийн тоо 9.0 - 9.2 хувиар өссөн байна.

Аймгийн музейн хамт олон 3.9 мянган үзмэрээр 7.1 мянган хүнд үйлчилж 7.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын хэмжээ 1.3 хувиар өссөн байна

Төв хөдөөгийн болон сургуулиудын 50 номын сан 77.0 мянган хүнд давхардсан тоогоор 333.2 мянган номоор үйлчилж оны эцэст 652.8 мянган ширхэг номын фондтой байна.

Сумдын соёлын төвүүд 2524 удаа урлаг, уран сайхны ажил зохиож түүнд давхардсан тоогоор 228.0 мянган хүн хамрагдаж 43.0 сая төгрөгийн орлоготой ажиллав.

2018 - 2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 33 сургуулийн 654 бүлэгт 17.1 мянган хүүхэд суралцаж, 36 цэцэрлэгт 7.4 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.9 мянган хүүхэд, 10-р ангид 1.1 мянган хүүхэд элссэний гадна 2.3 мянган хүүхэд ЕБСургуулийн дотуур байранд сууж байна.

Манай аймагт эдийн засгийн чиглэлийн 1 дээд сургууль ажиллаж түүнд 64 оюутан, МУБИС-ийн салбар Багшийн сургуульд 448 оюутан суралцаж байна. Аймгийн төвийн төрийн болон хувийн хэвшлийн гурван МСҮТөвд талх нарийн боовчин, тогооч, үсчин гоо сайханч, ХАА, хүлэмжийн аж ахуйн фермерч, компьютер албан хэрэг хөтлөгч, оёдол эсгүүрчин, автомашины болон цахилгаан хэрэгслийн засварчин, сантехникч гагнуурчин, барилгын өрлөг болон засал чимэглэгч, малын бага эмч, санитори, санхүүгийн туслах ажилтан зэрэг 15 гаруй төрлийн мэргэжлээр 1421 хүүхэд суралцаж байна.



## ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 518 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 308.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 115.5 мянган хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж 20.8 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 99.4 хувийг бүрэн хамруулсны дотор Хайрхан, Өгийнуур, Өлзийт, Хашаат, Төвшрүүлэх, Цахир сумд 100.0 хувь хамруулсан байна.


### Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Тайлант онд 1737 эхээс 1738 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 8.6 хувиар буюу 164 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 516 гарсан нь өнгөрсөн оныхоос 67 тохиолдлоор буюу 14.9 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 18.3, нас баралт 5.4 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 12.9 промил байна. Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 10 гарч мянган амьд төрөлтөд 5.7 ноогдож өнгөрсөн оныхоос 3 тохиолдлоор өссөн байна.

### Эндсэн хүүхдийн тоо



Нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 34 гарч мянган амьд төрөлтөд 20 ногдож байгаа нь өнгөрсөн оныхоос 2 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 61 нь буюу 582 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Батцэнгэл (111), Эрдэнэбулган(101), Ихтамир(91), Хашаат (74), Жаргалант (70) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 1.5 хувь нь гепатит, 22.2 хувь нь салхин цэцгээр, 44.2 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 10.8 хувь нь сүрьеэгээр, 21.3 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 15.6 хувиар буюу 91 тохиолдлоор өссөн байна.



### АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР


12 дугаар сарын 31-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1415 ажилгүй хүн байгаагийн 49.5 хувь нь буюу 701 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 244 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн

оныхоос бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 12.5 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.0 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 194 нь дээд, 56 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 1091 нь бүрэн болон бүрэн бус дунд, 59 нь бага боловсролтой хүмүүс байна.

12 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 609 хүн шинээр бүртгүүлж, 35 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж, 88 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Энэ онд аймгийн дүнгээр 1409 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар авч үзвэл Эрдэнэбулган сум 400, Өндөр-улаан, Ихтамир, Эрдэнэмандал, Цэнхэр, Тариат, Чулуут, Жаргалант, Хотонт сумд 61 - 99 ажлын байрыг, Төвшрүүлэх, Булган, Өлзийт, Хашаат, Цэцэрлэг, Батцэнгэл, Хангай сумд 41-58 ажлын байрыг Хайрхан, Цахир, Өгийнуур сумд 12-36 ажлын байрыг тус тус бий болгосон байна.

### Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо





## НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 онд 51.8 тэрбум төг, зарлага 51.3 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 4108.6 сая төг буюу 8.6 хувь, зарлага 3925.6 сая төг буюу 8.3 хувиар өссөн байна.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 4108.6 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 16.1 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 2.2 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 3.5 хувиар тус тус өссөн нь нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 8.3 хувиар өсөхөд тэтгэврийн, тэтгэмжийн, ҮОМШӨ-ний сангууд 3.5-15.7 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 46.5 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1.6 тэрбум төгрөгийг олгосон байна.

Энэ онд нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 23.8 мянган хүнд 13855 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 52.8 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 46.9 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 51.9 хувийг халамжийн тэтгэврээр, 27.9 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 20.2 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

### Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц



### ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 257 холбогдогч бүхий 519 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 160, өмчлөх эрхийн эсрэг 265, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 36, байгаль хамгаалах журмын эсрэг 18, бусад 40 хэрэг гарсан байна.

### Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо






Гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 215 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 1345.0 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 8.8 хувийг бүлэглэж, 18.6 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 604 хүнийг албадан саатуулж 225 хүнийг баривчилсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 1 хувиар буюу 5 тохиолдлоор өсөхөд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 1.3 хувиар буюу 2 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1.1 хувиар өссөн байна.

**Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо**



## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2018 онд аймгийн төсөвт 17864.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 23702.5 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 132.7 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 6726.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 8467.0

сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 119.2 хувиар биелүүллээ.

Төсвийн орлогын төлөвлөгөөг Төвшрүүлэхээс бусад бүх сумд 115.2 - 366 хувиар биелүүлсэн байна.




Орлогыг нэр төрлөөр нь ойн төлбөр, бууны татвар, иргэний орлогын албан татвар, цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвараас бусад нэрийн орлогуудыг 110.6 - 763.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 64.3 хувийг тусламжийн орлогоор, 22.3 хувийг орлогын албан татвараар, 1.5 хувийг өмчийн татвараар, 1.3 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 5.4 хувийг бусад албан татвараар, 3.5 хувийг татварын бус орлогоор, 1.7 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 319.4 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 1318.5 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 601 агаарын бохирдлын төлбөрөөр 27 сая төгрөг бүгд 2265.9 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 69073.4 сая төгрөг байгаагийн 45.7 хувийг цалин хөлсөнд, 5.4 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 48.7 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 41.7 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 48.1 хувийг боловсролын салбарт, 9.2 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.6 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.4 хувийг бусад салбарт зарцууллаа.

Орон нутгийн ᠔ пәәеі ääëäöëäāū í  
í èëò çàðëäāū í áçöýò, õòäëäð



## МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 23.5 тэрбум төгрөгийг авч 27.8 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

2018 онд банкууд 63 мянган иргэд, аж ахуй нэгжид 157 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 51 хүнд 1843.5 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.



Өнгөрсөн онтой зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 30.2 хувиар, олгосон зээлийн хэмжээ 32.9 хувиар өсч харин чанаргүй зээлийн хэмжээ 13.3 хувиар нэмэгдсэн бол, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 7.8 хувиар буурсан байна.



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2018 оны 12 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0.7 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.7 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 11 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан бараа үйлчилгээний үнэ тарифын 11 хувийнх нь өсч, 3 хувийнх нь үнэ буурч, 86 хувийнх нь үнэ тогтвортой

байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас лууван, өндөг, А-92 шатахуун, бохь, пивоны үнэ 0.2 – 6.3 хувиар буурч харин тахиа, үхрийн мах, сонгино, төмс, тараг, зөөлөн чихэр, үсний шампунь, эрэгтэй цамц, лааны үнэ 0.1 – 16.7 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 32,1 хувийнх нь буюу 122 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 14.2 хувийнх нь буюу 54 нэрийн барааны үнэ буурч, 53.7 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс шоколад, даралтны эм, бинзен шатахуун, хот хоорондын хүн тээврийн тасалбар, адуу үхэр хонь ямаа тахианы мах, шар будаа, ноосон цамц, кабелийн телевизийн хураамж, гүрж ногоон цай, далайн байцаа, мотоцикль, унадаг дугуй, гэрийн гадуур бүрээс, гар нүүрийн саван зэрэг барааны үнэ 0.2 - 80.0 хувиар нэмэгдсэн байна.




## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн дүнгээр 2018 оны эцэст 5482 мянган мал тоологдсоны дотор 0.02 хувь буюу 1.3 мянга нь тэмээ, 6.9 хувь буюу 378.4 мянга нь адуу, 11.3 хувь буюу 621.2 мянга нь үхэр, 54.4 хувь нь буюу 2981.8 мянга нь хонь, 27.3 хувь буюу 1499.3 мянга нь ямаа байна.

Өнгөрсөн оныхоос нийт малын тоо 3.5 хувиар буюу 190.3 мянган толгойгоор өссөний дотор хонь 4.6 хувиар буюу 136.7 мянган толгойгоор, ямаа 4.3 хувиар буюу 63.9 мянган толгойгоор тус тус өссөн байна. Харин тэмээ 9.3 хувиар буюу 128 толгойгоор, адуу 0.7 хувиар буюу 2.7 мянган толгойгоор,


үхэр 1.2 хувиар буюу 7.5 мянган толгойгоор тус тус буурсан байна.



Сумдаас Эрдэнэмандал 521.9 мянга, Хайрхан 404.2 мянган толгой малаар тэргүүлж байна. Батцэнгэл 389.8, Ихтамир 370, Өндөрүлаан 367.5, Цэцэрлэг 344.3, Хотонт 343.5, Цэнхэр 331.7, Хашаат 320.4, Өлзийт 302.9 гэсэн 8 сумд 300-аас дээш мянган толгой малтай, Тариат 292.2, Өгийнуур 278.3, Жаргалант 262.3, Эрдэнэбулган 215.9 гэсэн 4 сумд 200-аас дээш мянган толгой малтай, Чулуут 197.6, Төвшрүүлэх 161.4, Булган 145.8, Цахир 121, Хангай 120.2 гэсэн 5 сум 100-аас дээш мянган толгой малтай байна. Сумд дотроос адуугаар Цэнхэр 31.8, Хайрхан 30.4, Батцэнгэл 30.0 мянган толгойгоор, үхрээр Өндөрүлаан 60.7, Ихтамир 57.1, Цэнхэр 52.6 мянган толгойгоор, хониор Эрдэнэмандал 345.5, Хайрхан 250.3 Батцэнгэл 226.4 мянган толгойгоор, ямаагаар Хотонт 119.7, Эрдэнэмандал 105.5, Батцэнгэл 103.7 мянган

толгойгоор тус тус сумдыг тэргүүлж байна. Харин тэмээгээр Хашаат 474, Өгийнуур 367, Өлзийт 236 толгой тэмээтэйгээр сумдыг тэргүүлж байна.

### Төл бойжилтын хувь



Энэ онд оны эхний хээлтэгч малын 89,0 хувь нь буюу 1736.1 мянган эх мал төллөж гарсан төлийн 91.2 хувь нь буюу 1582.7 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботго 89.8 хувиар, унаганы 90.4 хувь, тугалын 92.4 хувь, хурганы 92.6 хувь, ишигний 87.5 хувь нь бойжиж байна. Сумдаас Чулуут, Булган, Тариат, Төвшрүүлэх, Жаргалант сумдад гарсан төлөө 95.0-аас дээш хувиар бойжууллаа.

2018 оны эцэст 167 гахай, 80 шувуу, 43 бүл зөгийг иргэд тэжээж бүтээгдэхүүнийг нь авч ашиглаж байна.

2018 оны эцсийн байдлаар малаа жилийн дөрвөн улиралд маллаж мал аж ахуйгаасаа өрхийн орлогын дийлэнхи хэсгийг олж амьдардаг 15160 малчин өрх байгаа нь өмнөх оныхоос 724 өрхөөр нэмэгдсэн байна.

Малчин өрхийн 87.2 хувь нь буюу 13 мянга нь цахилгаан гэрэлтэй, 72.3 хувь нь буюу 10.8 мянга нь телевизортой, 8.4 хувь нь радиотой, 40.1 хувь нь буюу 6 мянга нь оёдлын машинтай байна.


Аймгийн дүнгээр нийт малчин өрхийн 1.8 хувь нь буюу 270 өрх 10 хүртэл малтай, 4.8 хувь нь буюу 718 өрх 11-30 хүртэл, 4.8 хувь нь буюу 715 өрх 31-50 хүртэл, 10.8 хувь нь 1622 өрх 51-100 хүртэл, 21.8 хувь нь буюу 3269 өрх 101-200 хүртэл, 34.8 хувь нь буюу 5216 өрх 201-500 хүртэл, 15.5 хувь нь буюу 2329 өрх 501-999 хүртэл, 5.6 хувь нь буюу 839 өрх 1000-аас дээш малтай байна. 2017 оныхтой зэрэгцүүлэхэд нийт малчин өрхийн 44.0 хувь нь 200 хүртэл малтай байгаа нь 2.7 пунктээр буурч харин 201-999 малтай өрхийн эзлэх хувь 2.6 пунктээр, 1000-ээс дээш малтай өрхийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээгээр 1000-аас дээш толгой малтай 839 өрх байгаагийн 42 нь 2001-ээс дээш малтай, 93 нь 1500-2000 малтай, 704 нь 1000-1499 малтай байна. Аймгийн хэмжээнд нийт 24.8 мянган малын хашаа байгаагаас 4.9 мянган дулаан байр, 14.3 мянган саравчтай байр, 5.6 мянган саравчгүй байр байна. Бод малын хашаа 2127 ширхэг байна.

Энэ онд улс орон нутгийн төсвийн болон төсөл хөтөлбөрийн 262.2 сая төгрөгөөр 20 худаг шинээр гаргаж 24.6 сая төгрөгөөр 15 худгийг засварласан байна.

2018 онд оны эхний мал 94.2 хувиар онд орж оны эхний малын 5.8 хувь буюу 319,4 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 0.02 хувийг тэмээ, 9.9 хувийг адуу, 18.4 хувийг үхэр, 42.0 хувийг хонь, 29.6 хувийг ямааны хорогдол эзэлж байна.



### Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Сумдаас Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Тариат, Булган сумд оны эхний малаа 97.2 - 99.7 хувиар онд оруулан хамгийн бага хорогдолтой байна. Харин Хотонт суманд оны эхний малын 15.6 хувь буюу 53.4 мянган мал, Өгийнуур сумын оны эхний малын 8.8 хувь буюу 24.4 мянган мал, Хашаат суманд оны эхний малын 8.4 хувь буюу 27 мянган мал, хорогдсон нь хамгийн их хорогдолтой байна.


Энэ онд аймгийн дүнгээр 6913.1 га-д үр тариа, 252.4 га-д төмс, 107.3 га-д хүнсний ногоо, 2155 га-д малын тэжээлийн ургамал, 1178 га-д техникийн ургамал тус тус тариаллаа.

Өнгөрсөн онтой зэрэгцүүлэхэд тариалсан үр тариа 10.3 хувиар, төмс 47.4 хувиар, хүнсний ногоо 37.6 хувиар, , техникийн ургамал 15.9 хувиар бага тариалсан бол тэжээлийн ургамал 16.8 хувиар илүү тариалсан байна.

Аймгийн дүнгээр үр тариа 6639.5 тн, төмс 2113.8 тн, хүнсний ногоо 477.8 тн, тэжээлийн ургамал 5817 тн, техникийн ургамал 708.2 тонныг хурааж аваад байна. Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд хураан авсан тэжээлийн ургамал 24.8 хувиар илүү харин хүнсний ногоо 59.9 хувиар, үр тариа 9.2 хувиар, төмс 40.1 хувиар бага байна.

Мөн 70.8 мян.тн байгалийн хадлан, 1155.3 тн гар тэжээл бэлтгэсний дотор сумын аюулгүйн нөөцөнд 683.5 тн өвс, 306.3 тн тэжээл нөөцөлсөн байна.

### Хураасан үр тариа, төмс хүнсний ногоо тн-оор



2018 онд манай аймаг ойгоос 96.6 мянган м3 галын түлээ, 11 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 107.6 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас 171.2 мянган м3 галын түлээ, 11.9 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 183.1 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 293.6 сая төгрөг төсвийн орлогод оруулж, ойн зөрчилд 6.5 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.



### АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2018 онд оны үнээр 6249.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 0.6 хувиар их байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 2355.9 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.4 хувиар өссөн байна.

Нийт үйлдвэрлэлтийн 11 хувийг хүнс ундааны, 1.5 хувийг хэвлэлийн, 58 хувийг дулааны эрчим хүчний, 14.4

хувийг усан хангамж, 4.9 хувийг модон эдлэлийн, 3.4 хувийг барилгын материал, 6.5 хувийг гутал хувцасны, 0.4 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэрчсэн гурил, савласан болон түгээсэн цэвэр ус, монгол гутал, монгол дээл, гэрийн мод, модон тавилга, савхин гутал, эсгий шаахай, вакум цонх үйлдвэрлэлт 0.7 - 82 хувиар нэмэгдлээ. Харин хэрчсэн гурил, дулаан, монгол гутал, хүрмэн блокны үйлдвэрлэлийн хэмжээ 0.2 – 40.7 хувиар буурсан байна.



## БАРИЛГА

Барилгын байгууллагууд 9335.9 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7 хувиар буурсан байна. Нийт ажлын 83.4 хувь нь барилга угсралтын ажил 16.6 хувь нь их засварын ажил байна.



## ТЭЭВЭР

Тээврийн байгууллагууд 57.8 мянган зорчигч, 61.3 мянган тонн ачаа тээвэрлэн 26.9 сая хүн км, 7.9 сая тнкм ажил гүйцэтгэн 680.6 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлтийн хэмжээ 2.1 хувиар буурсан байна. Харин ачаа эргэлт, тээсэн ачаа 1.1-119.1 хувиар нэмэгдсэн байна.

Холбооны байгууллагууд 409 телефон цэг, улс хот хоорондын телефоны яриа, интернет, телевизийн болон шуудангийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 335.1 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оныхоос 4.1 хувиар буурсан байна.



## ЦАГ УУРЫН БАЙДАЛ

12 дугаар сард агаарын дундаж температур -16.3-аас-22.3 хэм хүйтэн байсан бөгөөд хамгийн их дулаан Төвшрүүлэх, Хашаат, Хотонт, Өгийнуур, Эрдэнэбулган сумдад 5.0 – 7.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өндөр-улаан, Хангай, Чулуут, Тариат, Батцэнгэл сумдад –35.0-ээс – 38,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна. Энэ сард Хотонт, Эрдэнэбулган, Төвшрүүлэх сумдын нутгаар 1.5 - 4.3 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хайрхан, Өлзийт, Цахир сумдад цас ороогүй байна.

**Статистикийн хэлтэс**  
**2019.01.15**